



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/374

Булган сум

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн XII/21 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Гэр цэцэрлэгийг шинэчлэх (15 ш) нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хорооны 2023 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан "Дөрвөлжийн бэл" ХХК-тай 66 901 680 /Жаран зургаан сая есөн зуун нэг мянга зургаан зуун ная/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Ганболд)-т олгосугай.

2. Нийлүүлж буй бараанд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Ганболд)-т үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан барааг холбогдох хууль тогтоомж, стандарт, техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлж хүлээлгэн өгөхийг "Дөрвөлжийн бэл" ХХК-ийн захирал (Н.Энхцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323010372